| 116. Ядамжавын Оросоо | - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн операторч, дэд ахлагч | 133. Пунцагийн Түмэнжаргал | - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн салааны захирагч, ахмад |
| 117. Цэндийн Отгонбаатар | - Барилгын цэргийн 017 дугаар батальоны ахлах харуул, ахлах ахлагч | 134. Бадамын Тэнүүнбаяр | - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жолооч-сум зөөгч, ахлагч |
| 118. Дэмбэрэлийн Отгонбаяр | - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч | 135. Жамъянгийн Урантөгс | - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сургагч багш, ахмад |
| 119. Ганболдын Өлзий баяр | - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жолооч, сум зөөгч, ахлагч | 136. Цогоогийн Ууганбаяр | - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн хол хэмжигч, тагнуулчин, дэд ахлагч |
| 120. Даш-Осорын Пүрэвсүрэн | - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн тасгийн дарга, дэд хурандаа | 137. Уламбаярын Хишигдэлгэр | - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч |



138. Батчулууны Хуралбаатар	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жолооч, ахлагч	157. Сандагийн Энхболд	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жолооч, дэд ахлагч
139. Дүгэрсүрэнгийн Хуралбаатар	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сумлагч, дэд ахлагч	158. Жамъянсүрэнгийн Энхболд	- Зэвсэгт хүчний жанжин штабын туслах мэргэжилтэн, ахлах ахлагч
140. Лувсангийн Хүрэлсүх	- Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн салааны захирагч, ахлагч	159. Лувсаншаравын Энхболд	- Барилгын цэргийн 047 дугаар батальоны бүлгийн дарга, ахлах ахлагч
141. Балдангийн Цогбадрах	- Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч	160. Рэнцэнгийн Энхболд	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч
142. Гомбын Цогбадрах	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сургагч багш, хошууч	161. Оюунгэрэлийн Энхболд	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик-операторч, дэд ахлагч
143. Ономын Цоггэрэл	- Барилгын цэргийн засвар механикийн заводын бүлгийн дарга, ахлах ахлагч	162. Цагаанцоожийн Энхболд	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн нууцдын дарга, дэслэгч
144. Сүхбаатарын Цогтжаргал	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жолооч, ахлагч	163. Очирбатын Энхээл	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тоотын захирагч, дэд ахлагч
145. Жанчивын Чогсомжав	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн албаны дарга, хошууч	164. Дамдинжавын Энхжаргал	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн механикч-жолооч, ахлагч
146. Намсрайн Чоймъятов	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик, дэд ахлагч	165. Балдандоржийн Энхтайван	- Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн экскаваторчин жолооч, ахлагч
147. Баатарын Чынбат	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сургагч багш, дэслэгч	166. Долгорсүрэнгийн Энхтүвшин	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн хол хэмжигч, тагнуулч, дэд ахлагч
148. Бямбаагийн Чинзориг	- Зэвсэгт хүчний жанжин штабын ахлах мэргэжилтэн, хошууч	167. Дашдоржийн Эрдэнэбаатар	- Барилгын цэргийн 047 дугаар батальоны бүлгийн дарга, ахлах ахлагч
149. Бадарчийн Чимэдцэрэн	- Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн засварын механикч, ахлах ахлагч	168. Пүрэвсүрэнгийн Эрдэмбилэг	- Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн их эмч, дэслэгч
150. Агваанпүрэвийн Шатар	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик, дэд ахлагч	169. Сумъяагийн Эрдэнэбилэг	- Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн автотехникийн дарга, дэслэгч
151. Наранбүрэнгийн Энхбаатар	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн машины дарга, дэд ахлагч	170. Бадамдоржийн Эрдэнэбулган	- Зэвсэгт хүчний жанжин штабын мэргэжилтэн, дэслэгч
152. Түвдэндоржийн Энхбаатар	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жолооч-сум зөөгч, дэд ахлагч	171. Цэнд-Аюушийн Эрхэмбаяр	- Батлан хамгаалахын их сургуулийн багш, ахмад
153. Баатарын Энхбат	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч	172. Гэмгүйн Ялалт	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
154. Цэнд-Аюушийн Энхбат	- Барилгын цэргийн засвар механикийн заводын гагнуурчин, ахлах ахлагч		
155. Шоовдорын Энхбаяр	- Барилгын цэргийн 017 дугаар батальоны мужаан, ахлагч		
156. Дамдинжавын Энхбаяр	- Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жолооч, ахлагч		

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Төрийн холбооны ашиглалтыг сайжруулж, төсөвт зардлыг хэмнэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Төрийн холбооны суурь сүлжээнд холбогдох техникийн нөхцөл бүрдсэн төр, захиргааны байгууллагуудын жагсаалтыг хавсралт ёсоор баталж, эдгээр байгууллагын холбооны үйлчилгээг хэвийн тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор холболтыг шуурхай хийж, төрийн холбооны систем, сүлжээний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Тагнуулын ерөнхий газрын дарга М.Батсайханд, төрийн холбооны сүлжээг нийтийн хэрэглээний холбооны сүлжээнүүдтэй холбох арга хэмжээ авч ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд тус тус даалгасугай.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлагуудын албан ажлын хэрэгцээнд гар утас хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудыг төрийн холбооны гар утсаар энэ оны 2 дугаар сарын 15-ны дотор хангахыг Тагнуулын ерөнхий газрын дарга М.Батсайханд үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбогдуулан төсөвт байгууллагуудын холбооны зардлыг 40 хувиар, гар утас хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудын гар утасны лимитийг 50

хувиар тус тус хэмнэх зарчмыг 2004 оны төсвийн жилд баримтлан ажиллахыг төрийн холбооны суурь сүлжээнд холбогдсон байгууллагуудын төсвийн ерөнхий менежерүүдэд даалгасугай.

4. Төрийн холбооны суурь сүлжээнд холбогдсон төр, захиргааны байгууллагуудын төрийн холбооны сүлжээгээр дамжиж гарсан харилцан холболтын буюу орсон, гарсан ярианы тооцоог "МЦХ", "Мобиком", "Скайтел" зэрэг үйлчлэгч байгууллага болон үйлчлүүлэгч байгууллага нэг бүрээр ярианы үргэлжилсэн хугацааг тулгаж, төлбөрийн гүйцэтгэл, зөрүүг тооцон гаргаж байхыг Тагнуулын ерөнхий газрын дарга М.Батсайханд, тооцоог хянан үзэж санхүүжилтийг суутган тооцож байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н. ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ДЭД БҮТЦИЙН
САЙД Б. ЖИГЖИД

Засгийн газрын 2004 оны 10 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ХОЛБООНЫ СУУРЬ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ БҮРДСЭН ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Хэрэглэгчийн тоо
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар	47
2	Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газар	222
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	85
	Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар	78

4	Ерөнхий сайдад харьяалагддаг агентлагууд:	
	Тагнуулын ерөнхий газар	445
	Радио, телевизийн хэрэг эрхлэх газар	25
	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	60
	Улсын мэргэжлийн хяналтын газар	100
	Төрийн өмчийн хороо	20
	Гамшгаас хамгаалах ерөнхий газар	39
5	Гадаад хэргийн яам	100
	Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар	20
	Хилийн комисс	10
6	Санхүү, эдийн засгийн яам	53
	Үндэсний татварын ерөнхий газар	35
	Улсын гаалийн ерөнхий газар	10
7	Хууль зүй, дотоод хэргийн яам	38
	Хил хамгаалах ерөнхий газар	45
	Цагдаагийн ерөнхий газар	22
	Эрүүгийн цагдаагийн газар	9
	Мөрдөн байцаах газар	6
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	45
	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	20
8	Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв	6
	Байгаль орчны яам	33
9	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	20
	Батлан хамгаалах яам	39
10	Зэвсэгт хүчний жанжин штаб	42
	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	17
	Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар	4
11	Дэд бүтцийн яам	13
	Аялал жуулчлалын газар	10
12	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	8
	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар	10
	Хөдөлмөр эрхлэлтийн газар	10
	Улсын нийгмийн халамжийн газар	10
13	Үйлдвэр, худалдааны яам	11
	Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газар	10
	Стандарчилал, хэмжил зүйн төв	20
	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар	20
14	Хүнс, хөдөө аж ахуйн яам	
	Улсын мал эмнэлэг, үржлийн газар	75

15	Эрүүл мэндийн яам	100
16	Үндсэн хуулийн цэц	16
17	Улсын дээд шүүх	44
18	Шүүхийн ерөнхий зөвлөл	5
19	Улсын ерөнхий прокурорын газар	10
20	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	9
21	Үндэсний аудитын газар	27
22	Үндэсний статистикийн газар	20
23	Үнэт цаасны хороо	15
24	Төрийн албаны зөвлөл	17
25	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	50
26	Аймгийн Засаг даргын Тамгын газрууд	315
	Аймгуудын хууль, хяналтын байгууллагууд	121
27	Сонгуулийн ерөнхий хороо	6
28	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс	4
29	Хүний эрхийн үндэсний комисс	4

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 33 дугаар зүйл, Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийн 1.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн өмчийг 2004 онд хувьчлах хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгах нь:

а/энэхүү хөтөлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу холбогдох яамдтай хамтран зохион байгуулж хэрэгжүүлсүгэй;

б/Төрийн өмчийг 2004 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 2 дугаар хавсралтад заасан аж ахуйн нэгжүүдээс өөрчлөн байгуулалтыг хийж дууссан, хувьчлалын бэлтгэл хангагдсан аж ахуйн нэгжийг 2004 онд хувьчлах арга хэмжээ авсугай;

в/хувьчлах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн худалдагдах үнийн дүнгийн 10 хүртэл хувьд

хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан ягаан тасалбарыг төлбөрт тооцон авсугай.

3. Баян-Өлгий аймагт байгаа хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан цэнхэр тасалбарын үлдэгдлийг эзэмшигчидтэй нь тохиролцон "Монголын хөрөнгийн бирж" ХК дээр арилжаалахаар нийлүүлэлт хийгдсэн "Товь" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа болон төрийн өмчийн оролцоотой бусад хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцаанд оруулан дуусгах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ), Үнэт цаасны хороо (С.ГҮНДЭНБАЛ)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

Засгийн газрын 2004 оны 13 дугаар
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ 2004 ОНД ХУВЬЧЛАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Өмч хувьчлалын зорилго

Улсын Их хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д заасан зорилт, зарчмыг удирдлага болгон үнэ цэнэтэй аж ахуйн нэгж болон бусад аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгийг хувьчилж, эдийн засаг дахь хувийн хэвшлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд өмч хувьчлалын зорилго оршино.

Хоёр. Өмч хувьчлалын зарчим

"Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д тусгагдсан зарчмыг баримтална.

Гурав. Хувьчлах аж ахуйн нэгжийн
жагсаалт

Дор дурдсан жагсаалтын дагуу аж ахуйн нэгжүүдэд өөрчлөн байгуулалт хийж, хувьчлалын бэлтгэлийг ханган хувьчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ:

1/2004 онд хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалт /1 дүгээр хавсралт/;

2/2004 онд өөрчлөн байгуулалт хийх болон хувьчлалын бэлтгэлийг хангах аж ахуйн нэгжийн жагсаалт /2 дугаар хавсралт/.

Дөрөв. Хөтөлбөр, жагсаалтад нэмэлт,
өөрчлөлт оруулах

Хөтөлбөр, хувьчлах аж ахуйн нэгж, өөрчлөн байгуулалт хийх болон хувьчлалын бэлтгэлийг хангах аж ахуйн нэгжийн жагсаалтад дор дурдсан нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

4.1. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн болон дотоод, гадаадын аж ахуйн нэгжээс тодорхой аж ахуйн нэгжийг хувьчлан авах санал хүсэлт гаргасан тохиолдолд;

4.2. Хувьчлах шийдвэр гарсан боловч холбогдох хууль тогтоомжийн дагуу татан буулгах, өөрчлөн зохион байгуулах шаардлагатай болсон аж ахуйн нэгжийг жагсаалтаас хасна;

4.3. Тодорхой салбар, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд олон улсын банк, санхүүгийн байгууллага болон хандивлагчдын зүгээс томоохон хэмжээний төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбогдсон тусгай шаардлага гарсан;

4.4. Тухайн аж ахуйн нэгжийг энэхүү хөтөлбөр, жагсаалтад зааснаас өөр аргаар хувьчлах талаар үндэслэлтэй санал, дүгнэлт гарч, холбогдох яам дэмжсэн бол;

4.5. Хувьчлалын бэлтгэлийг хангах явцад зайлшгүй урьдчилан шийдвэрлэвэл зохих асуудал гарсан аж ахуйн нэгжийг жагсаалтаас хасна;

4.6. Жагсаалтад орсон аж ахуйн нэгж хуваагдах буюу тусгаарласны үндсэн дээр шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжийн компанийнхаа анхны нэрийг өвлөн аваагүй тохиолдолд жагсаалтад орсон аж ахуйн нэгжийн нэрийг жагсаалтаас хасч, шинээр бий болсон аж ахуйн нэгжийн нэрийг холбогдох жагсаалтад оруулах, тухайн аж ахуйн нэгжийг салган хувьчлуулах санал гарч, түүнийг холбогдох яам болон Төрийн өмчийн хороо албан ёсоор зөвшөөрсөн, тухайн аж ахуйн нэгж өр, эзэлтэй бол томоохон зээлдүүлэгчийн зүгээс тодорхой санал гарсан тохиолдолд;

4.7. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр төрийн эзэмшлийн хувьцаанд өөрчлөлт орсныг Үнэт цаасны хорооноос зөвшөөрсөн тохиолдолд энэхүү шинэчлэн тогтоосон хувийг хувьчилна.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах

Энэхүү хөтөлбөрийн биелэлтийг 2005 оны 1 дүгээр сарын 25-ны дотор Төрийн өмчийн хороо холбогдох яам, газартай хамтран гаргаж Засгийн газарт тайлагнана.

"Төрийн өмчийг 2004 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 1-р хэсрэлт

2004 онд хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалт

ДД	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил /оймга, хот, сум, дүүрэг/	Үндсэн үйл ажиллагаа	Хувьчлах төрийн өмчийн хувь	Хувьчлалтыг зарлах хүтээх үйлчилгээ	Хувьчлах арга, хэлбэр, нөхцөл
0	1	2	3	4	5	6
1	"Дулааны II цахилгаан станц" ТӨХК	Улаанбаатар, Сонгино-хайрхан	Цахилгаан, дулаан үйлдвэрлэл	100	II	Европын сэргээн босголт, хөгжлийн банкны "Эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хувьчлалын стратегийг боловсруулж хэрэгжүүлэх төсөл" -тэй уялдуулан нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар
2	"Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Улаанбаатар, Багануур	Цахилгаан түгээх	100	II	Европын сэргээн босголт, хөгжлийн банкны "Эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хувьчлалын стратегийг боловсруулж хэрэгжүүлэх төсөл" -тэй уялдуулан нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар
3	"Хөвд цахилгаан түгээх сүлжээ" ХХК	Хөвд	Цахилгаан түгээх	100	I-II	Европын сэргээн босголт, хөгжлийн банкны "Эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хувьчлалын стратегийг боловсруулж хэрэгжүүлэх төсөл" -тэй уялдуулан нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар
4	"Улаангом цахилгаан түгээх сүлжээ" ХХК	Увс	Цахилгаан түгээх	100	II	Европын сэргээн босголт, хөгжлийн банкны "Эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хувьчлалын стратегийг боловсруулж хэрэгжүүлэх төсөл" -тэй уялдуулан нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар
5	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Улаанбаатар, Сонгино-хайрхан, Баянзүрх	Цахилгаан түгээх	100	II	Европын сэргээн босголт, хөгжлийн банкны "Эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хувьчлалын стратегийг боловсруулж хэрэгжүүлэх төсөл" -тэй уялдуулан "Дулааны III цахилгаан станц" ТӨХК-тай хамт болцлон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар
6	"Дулааны III цахилгаан станц" ТӨХК	Улаанбаатар, Хан-Уул	Цахилгаан, дулаан үйлдвэрлэл	100	II	Европын сэргээн босголт, хөгжлийн банкны "Эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хувьчлалын стратегийг боловсруулж хэрэгжүүлэх төсөл" -тэй уялдуулан "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-тай хамт болцлон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар

7	"Хотөл цемент шохой" ХК	Сэлжэг, Сайхан	Цемент, шохой үйлдвэрлэл	100	I-II	Цахилгаан үйлдвэрлэлийн төхив, тохилогийг орчин үеийн түршигд шивнэжлэн сайжруулж, Монгол Улсын экспортод гаргах бүтэцдэхүүний нэр төрлийг олшруулах, үйлдвэрийн орчны экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, Хотой тослогыг дулаанаар хангах Дулааны станцыг барих нөхцөлтийг эер гэдгээд, дотоодын хөрөнгө оруулагчдын дунд нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
8	"Монголын цахилгаан холбоо" ХК	Улаанбаатар, Цингэлтэй	Цахилгаан холбооны үйлчилгээ	54.67	IV	1.Шуудан, цахилгаан холбооны газрын цахилгаан холбооны суурь сулжээний улс, хот хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бусад хөрөнгийг Солонгосын талын хувь нийлүүлэгчтэй зохицсон үндсэн дээр "Монголын цахилгаан холбоо" ХК-д шилжүүлж, Монголын талын төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг шавьшчин тогтооц. 2."Монголын цахилгаан холбоо" ХК-ийн Монголын талын төрийн эзэмшлийн хувьцааг байрлан стратегийн хөрөнгө оруулагчид уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
9	"Ховд цемент" ТӨҮГ	Ховд	Цемент	100	III	Нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
10	Монгол-Америкийн хамтарсан "Монгол америк" ХХК	Улаанбаатар, Хан-Уул	Ноос, ноолуур боловсруулах	45	I	Монголын талын эзэмшлийн хувьцааг байрлан үнэлж, "Компанийн тусгай хууль"-ийн дагуу бусад хувьцаа эзэмшигчид /Америкийн талд/ санал болгох, жэрэж бусад хувьцаа эзэмшигч /Америкийн тал/ санал болгосон хувьцааг аваагүй тохиолдолд багц хувьцааг "Монгол тэмээний ноос" ТӨҮГ-тай хамт нээлттэй дуудлагын худалдааны аргаар хувьчлах
11	"Монгол тэмээний ноос" ТӨҮГ	Улаанбаатар, Хан-Уул	Ноос боловсруулах, ноолуур бүтээгдэхүүн үйлдвэрлэх	100	III	Нээлттэй дуудлагын худалдааны аргаар хувьчлах
12	"Булигаар" ХК	Улаанбаатар, Хан-Уул	Арьс, шир боловсруулах	69.5	I	Гадаад эзэл, өр төлбөрийн хамт нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
13	Монгол-Чехийн "Монголметалл" хамтарсан үйлдвэр	Улаанбаатар, Сонгино-хайрхан	Жонш, алт олборлолт	46	III-IV	1.Монгол, Чехийн Засгийн газар хоорондын хэлэлцэрлийг Чехийн талтай тохиролцон гэрээлж, 2.Чехийн талтай тохиролцсоны үндсэн дээр бүтцийн өөрчлөлт хийж, ХХК байгуулах, 3.Монголын талын эзэмшиж байгаа хувьцааг байрлан үнэлж, Компанийн тусгай хуулийн дагуу Чехийн талд худалдаж аваагүй санал болгох, 4.Чехийн тал аваагүй тохиолдолд нээлттэй дуудлагын худалдааны аргаар хувьчлах

"Төрийн өмчийг 2004 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 2-р хэсрэлт

2004 онд өөрчлөн байгуулалт хийх болон хувьчлалын бэлтгэлийг хангах аж ахуйн нэгжийн жагсаалт

д.д	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил (аймаг, хот, сум, дүүрэг)	Үндсэн үйл ажиллагаа	Харьяалах яам	Төрийн өмчийн хувь	Өөрчлөн байгуулалт хийх, хувьчлалын бэлтгэл хангах арга хэмжээ
1	"Шинэ-Ойсо" ХК	Говьсүмбэр	Нүүрс олборлох, борлуулах	ДБЯ	90	Японы талтай урьчилсан тохиролцож, төрийн эзэмшлийн хувьцааг багцлан нээлттэй урьдлаант шалгаруулалтын аргаар хувьчлах бэлтгэлийг хангах
2	"Багануур" ХК	Улаанбаатар, Баянзүр	Нүүрс олборлох, борлуулах	ДБЯ	75	Төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах оноотгой арга, хэлбэрийг сонгом, хувьчлалын бэлтгэлийг хангах
3	"Монгол шуудан" ХХК	Улаанбаатар	Шуудангийн үйлчилгээ	ДБЯ	100	Хувьчлалын бэлтгэлийг хангах
4	"Дарханмахэснэ" ХК	Дархан-Уул, Дархан	Мах үйлдвэрлэл	ХХААЯ	51	1. Японы Засгийн газрын буцаатгүй тусламжаар бий болсон хөрөнгийг бүртгэж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг шинэчлэн тогтоох. 2. Японы талтай буцаатгүй тусламжийн асуудлыг тохиролцсоны үндсэн дээр хувьчлалын бэлтгэлийг хангах
5	"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК	Улаанбаатар, Сүхбаатар	Үнэт шасны арилжаа	СЗЭЯ	100	Тус биржийн үйл ажиллагааны талаар гэривийчилсэн судалгаа, шинжилгээг хийж, бүтцийн өөрчлөлт хийх, удирдах үйл ажиллагааг нь гадаадын менежментийн багаар гүйцэтгүүлэх асуудлыг олон улсын санхүүгийн байгууллагуудад таних, хувьчлах стратегийн хөтөлбөрийг боловсруулах зэрэг асуудлыг шинлэвэрхэний үндсэн дээр хувьчлах
6	Халгалмажийн банк	Улаанбаатар	Банкны үйлчилгээ	СЗЭЯ	100	Хувьчлалын бэлтгэл хангагдаш нөхцөлд хувьчлах боллого баримтлах



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Хэлэлцээрт нэгдэн орсныг батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

дамжин өнгөрөх олон улсын хэлэлцээр"-т Монгол Улсын Засгийн газар нэгдэн орсныг баталсугай.

АНУ-ын Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан "Агаарын харилцааны

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД

Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Гадаадаас ажиллах хүч авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

нь:

1. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Авто зам хөгжүүлэх 2 дахь төсөл"-ийн хүрээнд Налайх-Мааньт-Чойрын чиглэлийн 200 км хатуу хучилттай зам барих БНХАУ-ын "China Tiesiju Civil Engineering Group" компанийн мэргэжлийн 1100 ажилтанг 2004 онд үе шаттайгаар авч ажиллуулахыг зөвшөөрч тэдгээрт Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

2. "China Tiesiju Civil Engineering Group" компанийг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хугацаанд ажлын байрны төлбөрөөс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Ш.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай

Боловсролын тухай хуулийн 43.2.4, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Амьдрал ядуу, нэн бага орлоготой ерх, иргэд болон ахмад дайчдын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1993 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 123 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

1. Оршин суугаа газраас нь 500 километр болон түүнээс хол байршилтай их, дээд сургууль, коллежид зохих журмын дагуу элсэн суралцагсдыг өвлийн амралтаараа орон нутагтаа очиж амрахад явсан баримтыг нь үндэслэн аймгийн төв хүртэлх тээврийн нэг талын зардлыг Сургалтын төрийн сангаар дамжуулан олгож байсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

2. Дээрх арга хэмжээнд 2004 онд шаардагдах хөрөнгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад багтаан санхүүжүүлж, цаашид жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2003-2004 оны хичээлийн жилээс өмнө их, дээд сургууль, коллежид зохих журмын дагуу элсэн суралцаж, сургалтын төрийн сангийн хөнгөлөлттэй зээлээр дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн төгсөгчдийг сургалтын төлбөрийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс бүрэн чөлөөлсүгэй.

2. "Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 158 дугаар тогтоолоор баталсан "Дотоодын их сургууль, коллежид суралцаж байгаа зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам"-ын дагуу төрийн санхүүжилтээр бакалаврын боловсрол эзэмшсэн хүмүүсийг салбарын хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгцээтэй газарт нь томилон ажиллуулж байсугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээг 2004 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД

А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Хугацаа сунгах тухай

Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь:

Тосон-Уул XIX, Тамсаг XXI, Буйр-XXII талбайтай холбогдуулж " СОКО Интернешнл" компанитай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрзэнүүд болон "Доншен Жингон газрын тосны олборлолтын групп" компанитай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрзэний эрэл, хайгуулын

хугацааг 5 жилээр сунгахыг Газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга О. Даваасамбууд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЙД БӨГӨӨД ҮЙЛДВЭР,
ХУДАЛДААНЫ САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2.5